

## ЖАЙКА-ГИЙН ТУХАЙ

Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА) нь 1990-ээд оноос Монголд үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд засаглал, боловсрол, тээвэр, байгаль орчны менежмент, хувийн секторын хөгжил зэрэг төрөл бүрийн салбарт буцалтгүй тусламж, хөнгөлттэй зээл, сургалт, техникийн хамтын ажиллагааны туслалцаа үзүүлж байгаа билээ.

“Мал эмнэлэг, МАА-н салбарын Хүний Нөөцийн Хөгжлийн Чадавхийг Бэхжүүлэх Төсөл” (VER) нь ЖАЙКА-гийн техникийн хамтын ажиллагааны төслийн нэг бөгөөд 2014 оноос малын эмч нарын мэдлэг, чадварыг сайжруулахаар хэрэгжиж байна. Энэхүү 5 жилийн хугацаатай төслийг хэрэгжүүлэхээр Хоккайдогийн Их Сургуулийн хүндэт профессор Үмэмүрагаар ахлуулсан төслийн баг Хөдөө Аж Ахуйн Их Сургууль (ХААИС)-тай нягт хамтран ажиллаж байна.

## ХОЛБОО БАРИХ

GET IN TOUCH

Төслийн оффис  
Улаанбаатар-17024, Зайсан, ХААИС

Tel (976) 89690256

✉ [yoshioka.shizuka@friends.jica.go.jp](mailto:yoshioka.shizuka@friends.jica.go.jp)

🌐 <https://www.jica.go.jp/mongolia/mon/office/index.html>

Мал эмнэлэг, МАА-н салбарын  
Хүний Нөөцийн Хөгжлийн  
Чадавхийг Бэхжүүлэх  
Төсөл (VER)





## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

ХААИС-ийн Мал Эмнэлгийн Сургууль (МЭС), Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам (ХХААХҮЯ)-ны академик болон үйлдвэрлэлийн сургалтын чадавхийг бэхжүүлэх

Төсөл хэрэгжсэнээр дараах үр дүнг бий болгоно:

1. МЭС-ийн сургалтын хөтөлбөр сайжрах
2. Шинэ сургалтын хөтөлбөрөөр сургалт явуулах МЭС-ийн боловсролын тогтолцоо бэхжих
3. МЭС-ийн боловсон хүчний заах аргын чадавхи бэхжих
4. Мал Эмнэлэг Үржлийн Газар (МЭҮГ)-ын үйлдвэрлэлийн малын эмч нарын сургалтын агуулга МЭС, Улсын Мал Эмнэлэг Ариун Цэврийн Төв Лаборатори (УМЭАЦТА), Мал Эмнэлгийн Хүрээлэн (МЭХ), Нийслэлийн Мал Эмнэлгийн Газар (НМЭГ)-ын дэмжлэгтэйгээр сайжрах

“

ЖАЙКА-гийн нийлүүлсэн багажны тусламжтайгаар мал эмнэлгийн сургалтын дадлага илүү чанаржиж байна!



## БИДНИЙ АЖИЛ

ХААИС-ийн МЭС, ХХААХҮЯ-ны сургалтын чадавхийг бэхжүүлэх үүднээс дараах үндсэн үйл ажиллагааг явуулж байна. Эдгээр нь шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх, мал эмнэлгийн салбарын өндөр түвшний япон мэргэжилтнүүдийг Монгол руу илгээх, монгол мэргэжилтнүүдийг Японд сургах зэрэг болно.



**ТОНОГ  
ТӨХӨӨРӨМЖ  
НИЙЛҮҮЛЭЛТ**

ЖАЙКА 4

тэрбум гаруй

төгрөгний тоног  
төхөөрөмж нийлүүлэнэ



**МЭРГЭЖИЛТЭН  
ИЛГЭЭХ**

2014-2019 онд уг


төслийн хүрээнд

давхардсан тоогоор

100 орчим

мэргэжилтэнг Монгол

руу илгээнэ



**МОНГОЛ  
МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ  
ЯПОНД СУРГАХ**

ЖАЙКА

50 гаруй монгол

мэргэжилтнүүдийг

Японд сургана

## ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



ЖАЙКА-гийн микробиологийн мэргэжилтэн оюутнуудад хичээл өрж буй нь



ЖАЙКА-гийн адууны тунуур хөдөлгөөний системийн мэргэжилтэн зүрхний бичлэлийн багаж ашиглан үзлэг хийж байна



Монгол мэргэжилтнүүд Японд сургалтанд хамрагдаж буй байдал



ЖАЙКА-гийн нөхөн үржихүйн мэргэжилтэн үзлэг хийж буй нь



ЖАЙКА-гийн эмгэг судлалын мэргэжилтэн задалан хийж үзүүлж байна

Итгэлээр дэлхийг холбоно

ЖАЙКА-гийн үзэл баримтлал